



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Цэцэрлэг хот
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор: П.Энхжаргал
Утас: 99743112
Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 1.Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 3 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 3 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 4 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 4 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 6 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 7 |
| 3. Аудитын тайлан..... | 7 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 7 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 7 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 8 |
| 3.4 Материаллаг байдал | 8 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 8 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 9 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 10 |
| 3.8 Аудитын гол асуудал | 10 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 10 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 10 |
| 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 11 |
| 3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 11 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 11 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

1.Аудитын санал дүгнэлт



ӨНДӨР-УЛААН СУМЫН ИТХ-ЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ч.ШАРАВЖАМЦ ТАНАА

2022.02.25 № 105
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөр-Улаан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Өндөр-Улаан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|----------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 87,500.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 87,500.00 | 0.00 |
| 35400 | Хангамжийн материал | 87,500.00 | 0.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 87,500.00 | 0.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 22,035,654.22 | 17,350,118.58 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 22,035,654.22 | 17,350,118.58 |
| 39200 | Биет хөрөнгө | 22,035,654.22 | 17,350,118.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 35,199,260.00 | 35,199,260.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -14,204,889.27 | -20,394,741.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,967,320.00 | 10,967,320.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,926,036.51 | -8,421,719.91 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 22,123,154.22 | 17,350,118.58 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 22,123,154.22 | 17,350,118.58 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 22,123,154.22 | 17,350,118.58 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 22,123,154.22 | 17,350,118.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 22,123,154.22 | 22,123,154.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -4,773,035.64 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 22,123,154.22 | 17,350,118.58 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|----------------------|----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 76,945,760.00 | 83,633,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 9,699,260.00 | 0.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,699,260.00 | 0.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,699,260.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,699,260.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 67,246,500.00 | 83,633,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 1,990,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,990,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 67,246,500.00 | 81,643,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 67,246,500.00 | 81,643,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 73,697,689.19 | 88,406,035.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 73,697,689.19 | 88,406,035.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 70,983,389.19 | 78,312,835.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 48,181,800.00 | 51,078,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 48,181,800.00 | 49,143,405.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 1,935,095.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,487,000.00 | 6,849,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,629,900.00 | 4,992,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 464,300.00 | 464,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 371,400.00 | 371,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 92,900.00 | 92,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 928,500.00 | 928,500.00 |

| | | | |
|-------------|---|---------------------|----------------------|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,949,650.00 | 6,661,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 849,650.00 | 858,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,400,000.00 | 3,500,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 202,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 1,800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,253,400.00 | 1,748,383.32 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,500,000.00 |
| 210602 | Тавилга | 800,000.00 | 28,383.32 |
| 210604 | Урсгал засвар | 453,400.00 | 220,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,050,000.00 | 800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,050,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,897,350.00 | 634,750.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,777,350.00 | 514,750.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 120,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,164,189.19 | 10,540,902.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 3,183,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 63,000.00 | 700,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,101,189.19 | 6,657,152.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,714,300.00 | 10,093,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,714,300.00 | 1,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,714,300.00 | 1,100,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.00 | 8,993,200.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 8,993,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 3,248,070.81 | -4,773,035.64 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 3,248,070.81 | -4,773,035.64 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 18,875,083.41 | 18,875,083.41 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 18,875,083.41 | 18,875,083.41 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 3,248,070.81 | 3,248,070.81 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 22,123,154.22 | 22,123,154.22 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 22,123,154.22 | 22,123,154.22 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 22,123,154.22 | 22,123,154.22 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -4,773,035.64 | -4,773,035.64 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 17,350,118.58 | 17,350,118.58 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|----------|---|----------------------|----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 67,246,500.00 | 83,633,000.00 |

| | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 67,246,500.00 | 83,633,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 1,990,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,990,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 67,246,500.00 | 81,643,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 67,246,500.00 | 81,643,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,796,500.00 | 81,633,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 66,796,500.00 | 81,633,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 64,082,200.00 | 71,539,800.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 48,181,800.00 | 51,078,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 48,181,800.00 | 49,143,405.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 1,935,095.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,487,000.00 | 6,849,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,629,900.00 | 4,992,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 464,300.00 | 464,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 371,400.00 | 371,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 92,900.00 | 92,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 928,500.00 | 928,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,540,000.00 | 3,696,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 440,000.00 | 482,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,400,000.00 | 2,714,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,000.00 | 200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 453,400.00 | 2,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 2,700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 453,400.00 | 0.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 1,050,000.00 | 800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилот | 1,050,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,670,000.00 | 1,726,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,550,000.00 | 1,606,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 120,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 700,000.00 | 4,690,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 3,450,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 700,000.00 | 1,240,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,714,300.00 | 10,093,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,714,300.00 | 1,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,714,300.00 | 1,100,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.00 | 8,993,200.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 8,993,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 450,000.00 | 2,000,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 450,000.00 | 2,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 450,000.00 | 2,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 450,000.00 | 2,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 450,000.00 | 2,000,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -450,000.00 | -2,000,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 0.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|-------------|--|----------------------|-----------------------------|---------------------|---------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 81,643,000.00 | 72,649,800.00 | 8,993,200.00 | 88.98 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 81,643,000.00 | 72,649,800.00 | 8,993,200.00 | 88.98 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 75,329,800.00 | 71,549,800.00 | 3,780,000.00 | 94.98 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 51,078,500.00 | 51,078,500.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 46,426,500.00 | 49,143,405.00 | -2,716,905.00 | 105.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,652,000.00 | 1,935,095.00 | 2,716,905.00 | 41.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,849,100.00 | 6,849,100.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,992,000.00 | 4,992,000.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 464,300.00 | 464,300.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 371,400.00 | 371,400.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 92,900.00 | 92,900.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 928,500.00 | 928,500.00 | 0.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,696,200.00 | 3,696,200.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 482,200.00 | 482,200.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,714,000.00 | 2,714,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,700,000.00 | 4,700,000.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,700,000.00 | 2,700,000.00 | 0.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,506,000.00 | 1,726,000.00 | 3,780,000.00 | 31.35 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,386,000.00 | 1,606,000.00 | 3,780,000.00 | 29.82 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,700,000.00 | 2,700,000.00 | 0.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 700,000.00 | 700,000.00 | 0.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,313,200.00 | 1,100,000.00 | 5,213,200.00 | 17.42 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,313,200.00 | 1,100,000.00 | 5,213,200.00 | 17.42 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,313,200.00 | 1,100,000.00 | 5,213,200.00 | 17.42 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 81,643,000.00 | 72,649,800.00 | 8,993,200.00 | 88.98 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 81,643,000.00 | 72,649,800.00 | 8,993,200.00 | 88.98 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 81,643,000.00 | 72,649,800.00 | 8,993,200.00 | 88.98 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 2.00 | 2.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|---------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,990,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,990,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,990,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,990,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,450,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 540,000.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,990,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,990,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,990,000.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өндөр-сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөр-Улаан сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөр-Улаан сумын ИТХ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахад байгууллагын зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөр-Улаан сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 81.6 сая төгрөгөөс 1%-иар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу буюу 0.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 4.8 сая төгрөгөөр буюу 21.6 хувиар буурсан байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь үндсэн хөрөнгийн данс байна.

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|----------------|-----------------|-------------|--------------|
| Бараа материал | 0.1 | | -0.1 | -100.0 |
| Үндсэн хөрөнгө | 22.0 | 17.4 | -4.7 | -21.2 |
| Нийт хөрөнгө | 22.1 | 17.4 | -4.8 | -21.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 22.1 | 17.4 | -4.8 | -21.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 22.1 | 17.4 | -4.8 | -21.6 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материал данс үлдэгдэлгүй байна.*

Бараа материалын данс нь 0.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 11.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст үлдэгдэлгүй байна.

- *Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 21.2 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 22.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 6.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 17.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 4.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт Б | /сая.төгрөг/ | | |
|--|---------------|-----------------|-------------------|
| | Өмнөх он 1 | Тайлант он 2 | Өөрчлөлт 3=2-1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 67.2 | 81.6 | 14.4 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 2 | 2 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9.7 | | -9.7 |
| Үйл ажиллагааны орлого | 76.9 | 83.6 | 6.7 |
| Бараа үйлчилгээний зардал | 71 | 78.3 | 7.3 |
| Урсгал шилжүүлэг | 2.7 | 10.1 | 7.4 |
| Үйл ажиллагааны зардал | 73.7 | 88.4 | 14.7 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 3.2 | -4.8 | -8 |

Өндөр-Улаан сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 14.4 сая төгрөг буюу 21.4 хувиар өссөн нь нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалтай холбоотой бөгөөд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 76.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 5.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 81.6 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 81.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 81.6 сая төгрөгийн санхүүжилт авч 72.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 9.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 3.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 5.2 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2.0 сая төгрөг Аймгийн ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зориулан зарцуулахаар ирсэн байна. Анхан шатны баримтаас тулган шалгахад 0.5 сая төгрөг цахим хурлын нэгжний зардалд, 1.5 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урамшуулалт эргүүлийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд хурлын төлөөлөгч нар тойргийн иргэдэд ковидоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргүүлэх ажлаар 1.0 сая төгрөгийн шатахуун зарцуулж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 91.2 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 81.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 72.6 сая төгрөгийг зарцуулж, 89.0 хувийн биелэлттэй.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Өндөр-Улаан сумын ИТХ нь 2.0 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өндөр-Улаан сумын ИТХ нь 2021 онд нийт 84.4 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 37.9 хувь буюу 9.0 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Төсвийн хөрөнгөөр 2.0 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өндөр-Улаан сумын ИТХ-ын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 31-ний 02/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------------------------------|----------------------|------------|-----------|-----|---------------|-----|-----------------|------------|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Өндөр-Улаан сумын ИТХ | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 2 | Өндөр-Улаан сумын ИТХ | 1 | 2.0 | | | | | 1 | 2.0 | | |
| НИЙТ ДҮН | | 1 | 2.0 | | | | | 1 | 2.0 | | |

/сая төгрөгөөр/